

АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ТӨСӨВ, 2027-
2028 ОНЫ САНГИЙН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ ХИЙСЭН
ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС

2025.06.23

2026 оны нийгмийн даатгалын сангийн төлөвлөгөөний төсөл 2026-2027 оны төсөөллийг хийхдээ НДЕГазрын 2025 оны Төсвийн төсөл, төсөөллийн санал боловсруулах 04/1364 тоот албан бичиг, газрын даргын А/18 тоот тушаалын дагуу 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсөөллийг боловсрууллаа. Төсвийн төслийг боловсруулахдаа 2023, 2024 оны гүйцэтгэлийг үндэслэн бусад хууль тогтоомж, дүрэм журам зааврын дагуу хийж гүйцэтгэлээ.

НДС-01 Маягт Төсөвт байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас төлөх шимтгэлийн орлогыг төлөвлөхдөө 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлийг тус тус үндэслэн 2025 оны хүлээгдэж буй нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төсөвлөлөө. 2026 оны Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төсвийг 2025 оны шимтгэлийн орлогыг 0.5 хувиар нэмэгдүүлэн тооцлоо. Харин Малчин нөхөн тооцох шимтгэлийн хууль хэрэгжиж эхлээгүй тул 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд тооцоогүй болно. Сайн дурын шимтгэлийн орлогын тухайд хамралтаараа биелэж байгаа боловч орлогын төлөвлөгөөгөөр биелэхгүй байна. Аж ахуйн нэгж байгууллагаас төлөх шимтгэлийн орлогыг 107.7 хувиар, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг 101.4 хувиар биелэхээр тус тус төлөвлөлөө.

НДС-02. 2026 онд ажил олгогчийн тоог 2024 оны гүйцэтгэл, 2025 оны эхний улирлын хамралтыг харгалзан төлөвлөсөн. Харин ажил олгогч, даатгуулагчийн тоог өмнөх оноос бууруулахгүй байхаар тооцож төсөвлөсөн. 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792000 төгрөг болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан нийгмийн даатгалын шимтгэлийн өсөлтийг уялдуулан тооцсон болно. Төсөвт байгууллагын батлагдсан цалингийн сан, аж ахуй нэг байгууллагын цалингийн сангийн 2024 оны гүйцэтгэлд үндэслэн төсөвлөсөн болно.

Сайн дурын даатгуулагчдын төлөх шимтгэлийн орлогыг төсөвлөхдөө 2024 оны гүйцэтгэлийг бууруулахгүй байхаар, 2025 оны төсвийн төсөлд өмнөх оны хувь хэмжээнээс тооцлоо. 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр сайн дурын даатгуулагчдын төлөх шимтгэлийн орлогыг 50 хувийн гүйцэтгэлтэй байхаар тооцсон. Цалингийн санг төсөвлөхдөө 2024 оны ААНБ болон төсөвт байгууллагуудын цалингийн сангийн гүйцэтгэлийг sicos програмаас нэг бүрчлэн орж даатгуулагчийн тоо, цалингийн сангийн судалгаанд үндэслэж тооцсон. Цаашид Sicos програмаас аж ахуйн нэгж байгууллагын даатгуулагчдын тоо, цалингийн сан, өмчийн хэлбэрээр харагддаг дэлгэрэнгүй судалгааг авдаг болгох саналтай байна.

НДС-07.1 Нийт тэтгэвэр авагчдын тоо болон зарцуулах хөрөнгийг 2023, 2024 онуудын гүйцэтгэлүүд, хүн амын насаар гаргасан статистик үзүүлэлт, дундаж наслалт, нас баралтын дүнтэй харьцуулан төлөвлөсөн. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны

04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулийн дагуу өндөр насны тэтгэвэрт 2026 онд гарахад эрэгтэй 60 нас, өөрийн хүсэлтээр бол 60 насанд хүрсэн 22 жил 3 сараас доошгүй хугацаанд шимтгэл төлж ажилласан эмэгтэй 55 нас хүрсэн иргэдийг өндөр насны тэтгэвэрт орохоор тооцоолж төсвийг хийлээ. Дундаж тэтгэврийг тэтгэврийн төрөл тус бүрээр тооцоолж төлөвлөв. 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тоо болон зарцуулах хөрөнгө нь жил тутамд буурхаар төсөвлөгдсөн болно. Учир нь 1995 оноос өмнөх шинээр тогтоох тэтгэвэр гэж байхгүй. Тэтгэврийн даатгалын сангаас 2024 онд нийт 17031 тэтгэвэр авагч нарт нийт-127.269.1 сая төгрөг зарцуулсан мөн 2025 оны хагас жилийн байдлаар нийт-17259 тэтгэвэр авагч нарт нийт-71.421.6 сая төгрөгийг зарцуулаад байна. Үүнээс харахад жил бүр тэтгэвэр авагчдын тоо, тэтгэврийн хэмжээ нэмэгдэж байгаатай уялдуулан мөн жил бүр хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын хэмжээ өсөх зэрэг тэтгэврийн хэмжээ өсөхөд нөлөөлж болохуйц байдалтай уялдуулан 2026 оны төсөв, 2027-2028 оны төсвийн төсөөллийг хийхдээ жил бүрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэн тооцсон болно.

НДС-07.2 Тэтгэвэр олголтын банкны үйлчилгээний хөлсний төсвийн төсөөллийг 2010 онд банкуудтай байгуулсан гэрээний дагуу болон тэтгэвэр авагчдын өсөлтийг харгалзан тооцоолов. 2026 оны төсөв, 2027-2028 оны төсөөллийг хийхдээ нэг тэтгэвэр авагчийн зардалыг өсгөөгүй хийсэн болно.

НДС-08. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн 2023, 2024 оны гүйцэтгэл, мөн нийгмийн даатгалын сангийн 2025 оны тодотгосон төсөв, 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлийн зарцуулалтыг тус тус үндэслэн тооцлоо. Үүнээс 2023 онд 3856.3 сая төгрөг, 2024 онд 5150.8 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас зарцуулсан байна. ХЧТА болон ЖАТ-ийг зардлыг 2025 оны 04 дүгээр сараас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792000 мянган төгрөг болж хэрэгжүүлсэнтэй холбогдуулан тооцож шаардагдах зардлыг тус тус тооцож төсөвлөсөн.

- Ажилгүйдлийн даатгалын тэтгэмжийг төсөвлөхдөө 2023, 2024 оны гүйцэтгэлийг үндэслэн, 2025 онд ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг эхний 5 сарын гүйцэтгэлтэй уялдуулан тооцоход 2055.8 сая төгрөг байна. Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж авагчдын тоог урьд оны гүйцэтгэл, жил бүрийн статистик судалгаанд үндэслэн ажиллаж байгаа болон тэтгэвэр авч байгаад нас барсан тэтгэвэр авагчдын судалгаанд үндэслэн тооцооллоо. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн зардал 2025 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өссөн мөн төрөлт, өвчлөл нэмэгдсэн, цалингийн дундаж хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор тэтгэмжийн зардал өсөхөөр байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж авагч нар сүүлийн жилүүдэд өсөж байгаатай холбогдуулан 2023, 2024 оны жилийн гүйцэтгэлийг үндэслэн мөн нийгмийн даатгалын сангийн 2024 оны тодотгосон төсөв, 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлийн зарцуулалтыг тус тус харгалзан 2026 оны төсөв, 2027, 2028 оны төсвийн төсөөллийг хийж гүйцэтгэлээ.

НДС-06. Хагас жилийн байдлаар өр авлагын судалгааг гарган , авлагаас санд оруулах орлогыг хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2025 онд хуримтлагдсан өр авлагыг бууруулж барагдуулахаар, цаашид урсгал авлагыг нэмэгдүүлэхгүйгээр төлөвлөв.

НДС-07. Даатгуулагчдаас тус байгууллагад 2023, 2024, 2025 оны хагас жилийн байдлаар сэргээн засах төв болон сувилалт ирэх, буцах унааны зардлын төлбөрийг гаргуулах тухай нэхэмжлэл ирүүлээгүй тул төлөвлөлт хийгээгүй.

НДС-08. 2 буюу түүнээс дээш байгууллагад ажиллаж хөдөлмөрийн хөлсний дээд хязгаараас давсан шимтгэл төлөлтийн буцаан олголтыг төлөвлөхдөө өмнөх жилүүдийн гүйцэтгэлийг үндэслэн өсгөхгүйгээр төсөвлөсөн.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ГЭРЭЛЧИМЭГ